

Осолд дөхсөн тохиолдол ослыг зөгнөдөг



1-р зураг. CCPS байгууллагын Үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагааны үзүүлэлтийн гарын авлага (2022 оны 4.1 хувилбар)-аас авсан Үзүүлэлтийн гурвалжин

Засварчин даралтат хийн системийн хаалтыг задалж эхэлсэн. Шугамын даралтыг сулласан байсан боловч үлдэгдэл даралт гадагшилсан. Засварчин гэмтэл аваагүй.

Оператор ажлын байраа эргэж яваад дээж авах хэд хэдэн цэгийн таглаа нь байхгүй, гэхдээ алдагдал үүсээгүй байгааг илрүүлсэн.

Эдгээр нь осолд дөхсөн тохиолдлын жишээ бөгөөд зарим компани үүнийг өртөхөд дөхсөн тохиолдол ч гэж нэрлэдэг.

Near-Miss

“Бодит хохирол, алдагдал учраагүй ч, өөр нөхцөл байдалд эсвэл даамжрах боломжтой байсан тохиолдолд хохирол, алдагдал учирч болох, төлөвлөгдөөгүй үйл явдал” (CCPS байгууллагын нэр томъёоны тайлбар)

Ихэнх оператор компаниуд осолд дөхсөн тохиолдлуудыг бүртгэж, шалгаж, шалгалтын тайланг цуглуулдаг. Эдгээр нь харьцангуй жижиг хэмжээний үйл явдал боловч эцэстээ ноцтой осолд хүргэж болзошгүй нөхцөл байдалтай байгааг илэрхийлэх сайн үзүүлэлт гэж үздэг. “Осолд дөхсөн” тохиолдлууд нь 1-р зурагт үзүүлсэн Үзүүлэлтийн гурвалжны 3-р түвшинд багтана. CCPS байгууллагын Үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагааны үзүүлэлтийн гарын авлага (2022 оны 4.1 хувилбар)-ыг дараах хаягаар үзэх боломжтой:

https://www.aiche.org/sites/default/files/docs/pages/ccps_process_safety_metrics_-_v4.1.pdf

Та мэдэх үү?

Осолд дөхсөн тохиолдлын жишээ:

- Үйл ажиллагааны журмыг олоод үзтэл хамгийн сүүлийн хувилбар нь биш байх.
- Үйлдвэрлэлийн нарийн хэмжүүр муудсан, эсвэл тохиргоо алдсан байх.
- Талбайн үзлэгийн тайланд мэдээлэл, өгөгдөл дутуу байх.
- Агуулахад байх ёстой бараа материал агуулахын гадаа хэд хонох.
- Осолд дөхсөн тохиолдол нь үйлдвэрлэлийн нэг эсвэл хэд хэдэн системд асуудал байгааг илтгэдэг. Засаж залруулахгүй бол цаашдаа илүү ноцтой тохиолдол гарч болзошгүй.
- Осолд дөхсөн тохиолдлыг шалгах хэрэггүй байж болох ч заавал мэдээлэх, бүртгэх, дүн шинжилгээ хийх, аюултай чиг хандлага байгаа эсэхийг тогтоох хэрэгтэй.
- Компаниуд осолд дөхсөн тохиолдлыг тодорхойлох, мэдээлэх системтэй байдаг.
- Бүх осолд дөхсөн тохиолдол заавал ажлын талбай дээр гарах албагүй, хяналтын өрөө, засварын цех, хаана ч гарч болзошгүй.
- Осолд дөхсөн тохиолдлыг идэвхтэй мэдээлэх системтэй байх нь үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагааны эерэг соёлыг илтгэнэ.
- Олон компани осолд дөхсөн тохиолдлуудад тогтмол үнэлгээ хийж, сайжруулах боломжийг тодорхойлдог.

Та юу хийх ёстой вэ?

- Осолд дөхсөн тохиолдол (эсвэл өртөхөд дөхсөн тохиолдол)-ын тодорхойлолтыг мэддэг байх
- Өдөр тутмын ажилдаа осолд дөхсөн тохиолдлыг анзаарч байх. Та төсөөлснөөс ч олон тохиолдож байж мэднэ шүү.
- Осолд дөхсөн тохиолдлыг ахлах ажилтандаа мэдээлэх.
- Аюулгүй ажиллагааны хурал дээр осолд дөхсөн тохиолдлоос юу сурч авсныг асууж байх.

Осолд дөхсөн тохиолдлыг мэдээл. Жижиг асуудлыг засаж чадвал том ослоос сэргийлж чадна!